

ГАН ХИЙЦ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН

ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Улаанбаатар хот

2019.04.26

Ган хийц ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2018 оны ээлжит хурлыг 2019 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 11:40 минут компанийн ТУЗ-ийн даргын өрөөнд хийв.

Хуралд: Хувьцаа эзэмшигч М.Даваасүрэн, Би ди сек ҮЦК-ийн төлөөлөн А.Өлзиймаа, Л.Чинбат, Лувсандорж нар оролцлоо.

Хуралд тус компанийн хувьцаа эзэмшигчдийн 72,71% буюу 176297 ширхэг хувьцаа эзэмшигч хүрэлцэн ирсэн тул Компанийн тухай хуулийн дагуу хурлын ирц бүрдсэн гэж үзээд хурлыг эхлэв.

Хурлын даргаар Хувьцаа эзэмшигч М.Даваасүрэн, нарийн бичгийн даргаар О.Ууганцэцэг, ТУЗ-ийн гишүүн Э.Долгорсүрэн нарыг сонгож батлав.

Хурлын дарга хурлаар хэлэлцэх асуудал, хурлын дотоод журмыг тус тус танилцуулж, батлуулав. Хурлыг 11:50 минут эхэлж, 12:50 цагт дуусгахыг санал оруулж батлууллаа.

Бүх хэлэлцэх асуудлаа танилцуулж дуусаад санал хүсэлтээ хэлэх санал оруулж байна. /Хуралд оролцсон бүх гишүүд 100 хувь саналаар зөвшөөрөв

Хэлэлцэх асуудал:

1. Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэх
2. ТУЗ-ийн 2019 оны зардлын төсөв, Компанийн 2019 оны захиргаа, үйлчилгээний зардлын төсвийг батлах
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох

Хэлэлцсэн нь:

Хэлэлцэх асуудлыг бүгдийг танилцуулсны дараа санал асуулгадаа орох уу. / 100 хувь дэмжив/

Хэлэлцэх асуудлын дараалалын дагуу **ТУЗ-ийн хийсэн ажлын тайлан болон компанийн үйл ажиллагааны талаарх** мэдээллийг ТУЗ-ийн дарга М.Даваасүрэн танилцуулав. Тайлан дараах чиглэлээр тайланг танилцуулав.

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны тайлан
 - ТУЗ, дэргэдэх хороодын талаарх мэдээлэл
 - Ногдол ашгийн талаарх шийдвэр
 - Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017-2019 оны бүрэлдэхүүн
 - Хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл
2. Ган хийц ХК-ийн үйл ажиллагааны мэдээлэл
 - Танилцуулга
 - Удирдлагын бүтэц бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт

- Гүйцэтгэх захирал
- Компанийн үйл ажиллагааны төлөвлөгөө түүний хэрэгжилт
- 2018 оны улсад төлсөн татвар
- ТУЗ-ийн болон ЗАА-н 2018 оны төсвийн гүйцэтгэл
- 2018 оны бүтээн байгуулалтууд

2018 онд Ган хийц ХК-ийн Төмөр хийцийн үйлдвэр нь захиалгат ажил багатай жил байлаа. Төмөр хийц үйлдвэрлэл, барилга угсралт 1,145 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой, захиалгат ажлуудын хийгт төмөр хийцийн жин 150 тонн үйлдвэрлэсэн байна. 2018 онд 86,14 сая төгрөгийн татварын Улсын төсөвт төвлөрүүлсэн.

ТУЗ-ийн 2019 оны зардлын төсөв, компанийн үйл ажиллагааны 2019 оны зардлын төсвийн талаар танилцуулав.

Үйлдвэрлэл санхүүгийн төлөвлөгөөг хавсралтаар танилцуулж байна. Үйлдвэрлэлтийг 450 тонн буюу 1,44 тэрбум төгрөг, барилга угсралтын ажил 1,2 тэр бум төгрөг, нийтдээ 2,64 тэрбум төгрөг төсөвлөсөн байна.

Цалинг орон тооны талаар манай компани үндсэн тогтвор суурьшилтай ажиллуулах үүднээс анхаар ажиллаж байна. 2019 онд цалинг нэмээгүй урьд жилийн төсвөөр орж ирж байна.

Бас нэг гол зардал бол Төлөөлөн удирдах зөвлөлийн зардал байдаг энэ зардлыг 121,9 сая төгрөгөөр санал оруулсан байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох

Компанийн тухай хууль болон компанийн дүрмийн заалтуудыг үндэслэн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг хоёр жилд нэг удаа сонгох учиртай үүнтэй холбоотойгоор Хараат гишүүдэд 8 хүний нэр дэвшиж байна.

Үүнд: М.Даваасүрэн

Б.Эрдэнэбаяр

Д.Оюунзул

Б.Ганбат

Ц.Пүрэвжаргал

Э.Долгорсүрэн

Ц.Хангай

Г.Бат-энх

Хараат бус гишүүнд

Д.Энхбаатар

Ц.Жанлав

Д.Сайнбаяр нарын нэрийг дэвшүүлж байна. Та бүхэнд анкетыг хавсаргасан тул танилцана уу. Ихэнх хүмүүс маань олон жил идэвхтэй ажиллаж байгаа хүмүүс байна. Шинээр Ц.Хангай, Г.Бат-энх, Д.Сайнбаяр нар юм.

М.Даваасүрэн: Анхаарал хандуулсан баярлалаа. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал дууслаа та бүхэн санал хүсэлтээ хэлнэ үү.

Би ди сек ҮЦК-ийн төлөөлөгч А.Өлзиймаа: Хэлэлцсэн асуудал дээр нэмэх санал байхгүй. 2019 оны төсөв дээр нэмэх санал алга байна.

Лувсандорж: санал хүсэлт байхгүй тул дэмжиж байна.

Чинбат: Хэлэлцэж байгаа асуудлууд бүгд тодорхой, танилцуулагдсан тул татгалзах, асууж тодруулах зүйл байхгүй байна. Дэмжиж байна.

М.Даваасүрэн: Өөр асууж тодруулах зүйл байна уу. Байхгүй бол Тооллогын комисс байгуулж, ажилд нь оруулъя. Тооллогын комиссыг дараах хүмүүсийг сонгох саналтай байна. Энд байгаа хүмүүс тооллогын комисст орж болохгүй тул менежер, нягтлан бодогч нараас сонгох саналтай байна.

Тооллогын комиссын даргаар Эко цаг ХХК-ийн нягтлан бодогч Т.Мөнгөнчимэг

Гишүүд Бичиг хэрэг архивын эрхлэгч О.Мөнгөнтуяа

Бараа материалын нярав Г.Аззаяа

/100 хувийн саналаар батлав./

Тооллогын комисс бол таван асуудал дээр гурван санал хуудас хэвлэж санал хураалт явуулна.

1. Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг дүгнэх, Төлөөлөн удирдах зөвлөлийн төсөв, компанийн үйл ажиллагааны төсөв
2. ТУЗ-ийн хараат гишүүдийг сонгох
3. ТУЗ-ийн хараат бус гишүүдийг сонгох

Даваасүрэн: Та бүхэнд тарааж өгсөн материал дээр ТУЗ-ийн зардал, Компанийн үйл ажиллагааны зардлын төсвийн харуулсан тул уншиж танилцана уу.

Хурлын дарга М.Даваасүрэн: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудал дууссан тул Тооллогын комисс ажилдаа орж саналын хуудсыг тарааж өгнө үү. Ирсэн хувьцаа эзэмшигчид саналыг хуудсыг бөглөв./

Тооллогын комиссын дарга Т.Мөнгөнчимэг саналын дүн, тооллогын комиссын хурлын протокол, тогтоолыг уншиж танилцуулав. /протокол, тогтоолыг хавсаргав./

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээр сонгогдсон М.Даваасүрэн, Б.Эрдэнэбаяр, Д.Оюунзул, Ц.Пүрэвжаргал, Э.Долгорсүрэн, Ц.Хангай, Хараат бус гишүүнээр Д.Энхбаатар, Ц.Жанлав, Д.Сайнбаяр нарт Ажлын өндөр амжилт хүсч баяр хүргэе.

Шийдвэрлэсэн нь:

1. Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг ХАНГАЛТТАЙ гэж дүгнэв.
2. 2019 оны ТУЗ-ийн зардлын төсвийг 121 977 600 төгрөгөөр, Компанийн үйл ажиллагааны 2019 оны төсвийг 647 118 700 төгрөгөөр батлав.
3. ТУЗ-ийн хараат гишүүдийг сонгох асуудлаар хуралд оролцогчийн олонхийн саналаар М.Даваасүрэн, Б.Эрдэнэбаяр, Д.Оюунзул, Ц.Пүрэвжаргал, Э.Долгорсүрэн, Ц.Хангай нарыг, ТУЗ-ийн хараат бус гишүүдийг сонгох асуудлаар хуралд оролцогчийн олонхийн саналаар Д.Энхбаатар, Ц.Жанлав, Д.Сайнбаяр нарыг тус тус томилов.

Хурлын дарга М.Даваасүрэн хувьцаа эзэмшигчийн саналын дүнг үндэслэн шийдвэрлэсэн асуудалтай холбогдон гарах хурлын тогтоолын төслийг баталж, хурлаас гаргаж буй тогтоолыг уншиж танилцуулснаар хурал өндөрлөв. / тогтоолыг хавсаргав./

Хувьцаа эзэмшигчдийн хурал 2019 оны 04 дүгээр сарын 26 өдрийн 13:10 цагт өндөрлөв.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн :

Нарийн бичгийн дарга



О.Ууганцэцэг

Танилцсан:

Хурлын дарга

М.Даваасүрэн

Гишүүн

Э.Долгорсүрэн

